

**Монгол Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар  
сарын 22-ны өдөр (Мягмар гараг)-ийн  
хуралдааны гар тэмдэглэл**

Байнгын хорооны дарга А.Бакей ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 30 минутад Төрийн ордны “А” танхимд эхлэв.*

**Чөлөөтэй:** Н.Алтанхуяг, Сү.Батболд, Б.Наранхүү, Р.Гончигдорж;

**Тасалсан:** С.Баярцогт, Ж.Батзандан, Сү.Батболд, С.Дэмбэрэл.

**Нэг. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн дэд сайд С.Пүрэв, мөн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбат, Орлогын хэлтсийн дарга Б.Доржсэмбэд, Төсвийн зарлагын газрын дарга О.Хуягцогт, Төсвийн Орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр, Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн хэлтсийн дарга М.Батгэрэл, Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, мөн газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв, Санхүү, эдийн засгийн албаны ахлах референт С.Тэрбиш, Хяналт, үнэлгээний хэлтсийн Төсвийн шинжилгээний хэсгийн зөвлөх Г.Даваажаргал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга О.Очиржав, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга С.Цэдэндамба, Монголын радиогийн захирал С.Цэрэн-Очир, “ММ” агентлагийн дарга С.Батзаяа, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Сүхбаатар, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга М.Энх-Амар, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гүнбазар, Худалдан авах үйл ажиллагааны газрын дэд дарга С.Дашдондог, Оюуны өмчийн газрын дарга Н.Чинбат, Стандартчилал, хэмжил зүйн газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Э.Эрхэмбаяр, Төсвийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Т.Мөнхбаясгалан, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд дарга А.Ариунболд, ерөнхий нягтлан бодогч Д.Одгэрэл, Худалдан авах ажиллагааны газрын хэлтсийн дарга Д.Лхамсүрэн, мөн газрын хэлтсийн дарга Д.Тэгшдэлгэр, ерөнхий нягтлан бодогч Т.Оюунтуяа, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх О.Тунгалаг, М.Элбэгдорж нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**А.Бакей:** - Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг хийхийг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
Гишүүдийн олонхын саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 9 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.**

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Н.Батцэрэг, Л.Цог нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт, Х.Тэмүүжин, Л.Цог, Н.Батцэрэг, А.Бакей нар санал хэлсэн болно.

**А.Бакей:** - Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн саналд тулгуурлан 1 дүгээр заалтыг чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын ажлын уялдааг хангах, ажлын дэд хэсгийг тусад нь байгуулан ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг батлахыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
Гишүүдийн олонхын саналаар дэмжигдлээ.

**Хуралдаан 10 цаг 00 минутад өндөрлөв.**

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

А.БАКЕЙ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

М.НОМИНДУЛАМ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН НАМРЫН ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ 2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН 22-НЫ  
ӨДӨР (МЯГМАР ГАРАГ)-ИЙН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**А.Бакей:** - Эрхэм гишүүдийн өнөөдрийн амар амгаланг айлтгая. Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралд ирвэл зохих гишүүдийн хурлын ирц бүрдэж байна. М.Батчимэг гишүүн, Ж.Батзандан гишүүн, Р.Бурмаа гишүүн, Ч.Сайханбилэг гишүүн одоо замд ирж байгаа, эдгээр гишүүдийг оролцуулаад хурлын ирц бүрдэж байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар хоёр асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг байна.

Хоёрдугаарт, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Ийм хоёр асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлыг батлах саналтай гишүүд гараа өргөнө үү? Хэлэлцэх асуудлаа баталъя.

10-аас 7.

Хэлэлцэх асуудал батлагдлаа. Одоо дэгийн дагуу эхний асуудлыг хэлэлцэж эхэлье.

***Нэг. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/.***

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Сангийн яамнаас төлөөлж оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Сангийн дэд сайд С.Пүрэв, Сангийн яамны Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбат, Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга Б.Доржсэмбэд, Сангийн яамны Төсвийн зарлагын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Төсвийн Орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр, мөн яамны Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн хэлтсийн дарга М.Батгэрэл, Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамрагддаг байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагч нарыг төлөөлж ажлын хэсгийн гишүүд оролцож байна. Б.Болдбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Н.Ширэндэв Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга,

С.Тэрбиш Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүүгийн хэлтсийн ажилтан, Г.Даваажаргал Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, үнэлгээний хэлтсийн Төсвийн шинжилгээний хэсгийн зөвлөх, О.Очиржав Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга, С.Цэдэндамба Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, С.Цэрэн-Очир Монголын радиогийн захирал, С.Батзаяа “ММ” агентлагийн дарга, Сүхбаатар Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Сүхбаатар, М.Энх-Амар мөн газрын Санхүү, ар талын газрын дарга, Д.Гүнбазар Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, С.Дашдондог Худалдан авах үйл ажиллагааны газрын дэд дарга, Н.Чинбат Оюуны өмчийн газрын дарга, Э.Эрхэмбаяр Стандартчилал, хэмжил зүйн газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Т.Мөнхбаясгалан Төсвийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, А.Ариунболд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд дарга, Д.Одгэрэл мөн газрын ерөнхий нягтлан бодогч, Д.Лхамсүрэн Худалдан авах ажиллагааны газрын хэлтсийн дарга, Д.Тэгшдэлгэр мөн газрын хэлтсийн дарга, Т.Оюунтуяа мөн газрын ерөнхий нягтлан бодогч ийм хүмүүс оролцож байгаа гэдгийг мэдэгдье. Ингээд товчхон тайлбар хэлэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д бол Байнгын хороо нам эвслийн бүлгийн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд хууль санаачлагч болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэсэн ийм зохицуулалт байгаа. Мэдээж ерөнхий танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулсан учраас шууд асуулт хариулт тавиад эхлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Ингээд ажлын хэсгийн гишүүдээс асуух асуулттай гишүүд байна уу? Асуулттай гишүүд байхгүй байна уу? Асуулттай гишүүд байхгүй бол асуултыг тасаллаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу, санал гаргах? Байхгүй байна. Санал тасаллаа. Ингээд энэ дашрамд хэлэхэд бол Улсын Их Хурал өөрөө хууль тогтоох байгууллага учраас Улсын Их Хурлын Тамгын газрын, ажлын хэсэг жаахан байж байгаарай. Улсын Их Хурлын Тамгын газрын төсвийн тодотголыг оруулж ирэхгүй нийт дүнгээр танах мөнгөний хэмжээг тавьсны зэрэгцээ доторх урсгал зардлыг нэг бүрчлэн түүнээс тэдийг хас, эндээс тэдийг хас гэсэн ийм зохицуулалт ирсэн байна. Үүнийг нийт дүндээ багтааж Улсын Их Хурлын Тамгын газар өөрсдөө зохицуулах нь зүйтэй байх. Үүнийг протоколд тэмдэглэхийе. Дотроо чухам алийг нь яаж хасах нь бол гол асуудал биш шүү дээ, өөрсдөө шийдэх нь зүйтэй гэж үзэж байна. Ингээд ажлын хэсгийнхэнд баярлалаа. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлэг хийхийг дэмжье гэсэн гишүүд гараа өргөнө үү? Тоолоорой санал хурааж байгаа шүү.

10-аас 7.

Дэмжигдлээ. Ингээд 10-аас гэсэн биз дээ. Санал, дүгнэлтээ бид Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хоёр дахь асуудалдаа оръё.

**Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.**

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Энэ тогтоолын төслийг боловсруулах үндэслэл, танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл танилцуулахаар ярьчихсан байсан. С.Дэмбэрэл гишүүн хараахан ирээгүй байна. Тэгэхдээ яагаад ийм тогтоол гаргах болсон бэ гэвэл энэ оны турш бид хуралдах явцдаа Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс тодорхой саналууд гарч байсан. Жишээлбэл 2013 оны төсвийг хэлэлцэх явцад мөн үндсэн чиглэлийг хэлэлцэх явцад бол төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо төдийлөн хангалттай биш байна, тийм учраас энэ асуудлаар тодорхой ажлын хэсэг байгуулаад ажиллуулах шаардлагатай гэсэн гишүүдийн санал гарч байсан. Энэ гишүүдийн саналд тулгуурлаад өнөөдөр энэ бол 2013 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дээр ийм санал гарсан байна. Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцэх явцад энэ дагуу тогтоолын төслийг боловсруулсан байгаа. Монгол Улсын хөгжлийн хэтийн төсөөлөл, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, батлагдсан хууль тогтоомжийн уялдаа, хэрэгжилтийг хангах, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын бодлогыг төрийн байгууллагууд хэрхэн уялдуулж ажиллаж байгааг судалж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар санал болгож байгаа.

Энэ ажлын хэсгийн ахлагчаар өөрийнх нь зөвшөөрснөөр Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл, гишүүдэд бол Сүхбаатарын Батболд гишүүн, Сундуйн Батболд гишүүн, М.Батчимэг гишүүн, С.Баярцогт гишүүн, Н.Батцэрэг гишүүн, Р.Бурмаа гишүүн, тэгээд ажлын дэд хэсэг гэдэг ч юм уу мэргэжил арга зүйн талаасаа туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах хүмүүсээр А.Зангад Монгол Улсын Ерөнхий аудитор, С.Мэндсайхан Үндэсний статистикийн хорооны дарга, Б.Шинэбаатар Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Ганцогт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Энхбайгаль Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал, Н.Цогтсайхан Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн орлогч дарга, О.Тунгалаг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн зөвлөх, М.Элбэгдорж Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж байгаа.

Хоёрдугаарт, ажлын хэсгийн санал боловсруулж Төрийн байгуулалтын байнгын хороонд 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай гэсэн тогтоолын төсөл байна. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүн байна уу? Х.Тэмүүжин гишүүн, Н.Батцэрэг, Л.Цог гишүүн. Л.Цог гишүүнээр тасаллаа. Х.Тэмүүжин гишүүн асууя.

**Х.Тэмүүжин:** - Тогтоолын төслийн эхний хэсэг дээр их л өргөн харагдаж байна л даа. Монгол Улсын хөгжлийн хэтийн төсөөлөл боловсронгуй болгох, бодлого боловсронгуй болгох, төлөвлөлтийг боловсронгуй болгох, батлагдсан хууль тогтоомжийн уялдаа, хэрэгжилтийг хангах, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын бодлогыг

төрийн байгууллагууд хэрхэн уялдуулж ажиллаж байгааг судлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах гэсэн ийм бараг 3 том багц юм байгаа байхгүй юу. Хөгжлийн хэтийн төсөөлөл, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох гэдэг Төрийн байгуулалтын байнгын хорооны чиг үүрэг мөн үү, үгүй юу нэг.

Хоёрт нь болохоор хууль тогтоомжийн уялдаа хэрэгжилтийг хангах гэдэг бас Төрийн байгуулалтын байнгын хорооны чиг үүрэг мөн үү, үгүй юу. Ард байгаа төрийн байгууллагын хэрхэн уялдан ажиллаж байгаа гэдэг бол яах аргагүй Төрийн байгуулалтын байнгын хорооны чиг мөн. Жишээ нь хууль тогтоомжийн уялдаа хэрэгжилтийг хангах гэдэг бол цэвэр Хууль зүйн байнгын хорооны ажил байхгүй юу. Улсын хөгжлийн хэтийн төсөөлөл, бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох гэдэг бол эдийн засгийн аль хөгжлийг нь ярьж байгаа юм бэ, эдийн засаг ярьж байгаа бол Эдийн засгийн хөгжлийн яам, нийгмийн асуудлаар нь ярьж байгаа Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааныг хариуцсан байнгын хороо байгаа юм. Төрийн байгуулалтыг нь өөрийг нь илүү боловсронгуй болгох гэж байгаа бол манай Байнгын хорооны асуудал яах аргагүй мөн л дөө. Ийм учраас ерөнхий гарчиг өөрөө Улсын Их Хурлын даргын ажлын хэсэг байгуулах эрх хэмжээний асуудлын түвшинд оччихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ эргэж нэг ярилцахгүй бол Төрийн байгуулалтын байнгын хороо бусад Байнгын хорооны эрхлэх асуудлыг булааж авах байдлаар ийм хэмжээний том ажлын хэсэг байгуулж болох уу гэдэг бол жаахан эргэлзээтэй санагдаж байна. Хоёрт нь техникийн хувьд ажлын хэсгийн гишүүд гээд шууд үргэлжлүүлэхээсээ илүүтэйгээр дэд ажлын хэсгийг салгаж өгөхгүй бол эд нар чинь гишүүдтэй эн зэрэгцэх ажлын хэсгийн шийдвэр гаргахдаа эд нарын оролцуулж санал хураалгах хэмжээний болчихож магадгүй. Тийм учраас ялгах хэрэгтэй болов уу?

Туслах гэж байгаа хэсгээ тусад нь гаргаж өгчихөөд эцсийн дүндээ энэ ажлын хэсэг чинь санал хураагаад олон цөөнхөөрөө асуудлаа Байнгын хороогоор оруулж ирнэ шүү дээ. Тийм учраас гишүүдээ тусад нь салгаж бичих хэрэгтэй.

**А.Бакей:** - Баярлалаа, тэгэхээр энэ ерөнхий томъёоллын хувьд жаахан буруу ойлгогдож байж магадгүй. Яг шаардлага байна уу гэвэл байна. Өнөөдөр төрийн байгууллагуудын ажлын уялдаа бол үнэндээ тийм ч хангалтгүй байна. Жишээлбэл, үгүй би хариулт өгчихье асуулт асуусан учраас хариулж байгаа шүү дээ. С.Дэмбэрэл гишүүн ирэхгүй байгаа юм чинь Байнгын хорооны хувьд үндсэндээ би өөрөө зөвлөлдөөд энэ тогтоолын төслийг боловсруулсан байгаа. Тэгэхээр жишээлбэл яг одоо хэлэлцэж байгаа Монгол Улсын 2014 оны төсөв гэдэг ч юм уу, энэ дээр Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам өөр өөр тоо тавьчихаад орж ирж байна. Монголбанк бас өөр тоо тавиад ингээд төлөвлөлтийн талаасаа ажлын уялдаа байхгүй байна гэж үзэж байгаа. Түүнээс томъёоллын хувьд жаахан буруу ойлгогдож байж магадгүй. Түүнээс бусад Байнгын хороодын чиг үүргийг шууд татаж эндээ авчирч яах гэсэн юм биш энэ бол томъёоллыг нь хэтэрхий том ойлгогдохоор биш ойлгомжтой хэлбэрээр томъёолох талын саналыг хүлээж авч болно. Ерөнхийдөө гол санал нь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбоотой ажлын хэсэг гэсэн үг.

Дэд ажлын хэсгийг тусад нь гаргаж томъёолох нь зүйтэй үүнийг хүлээж авч

байна. Н.Батцэрэг гишүүн.

**Н.Батцэрэг:** - Ерөнхийдөө санаа давхардах гээд байна. Гэхдээ хэлье. Тогтоолын төслийн нэг дээр жишээлбэл Монгол Улсын хөгжлийн хэтийн төсөөлөл гэхэд чинь яг нарийндаа маш том улс төрийн шийдлийн тухай асуудал шүү дээ, манай өнөөдрийн тогтолцоон дотор бол хэдэн жилээр үзэж байгаа юм. Одоо бол манайд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал гээд тийм баримт бичиг байдаг. Тэр хүрээнд жишээлбэл нийгэм эдийн засгийн салбаруудаараа ерөнхий хөгжлийн төсөөллөө гаргачихсан юм байдаг л даа. Тэгэхээр Монголын Улсын хөгжлийн хэтийн төсөөлөл гэх юм бол энэ дотор фантаслаж болно энэ бол их хэцүү томъёолол харагдаад байна л даа. Хугацаа ойлгомжтой байвал арай өөр болно. Тэгээд бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох, төлөвлөлт гэдэг дотор нь яг алийг хэлээд байгаа юм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт үү, юу байна вэ гэх мэтчилэн. Бодлого гэдэг чинь өөрөө их том зүйл шүү дээ. Төрийн бодлого гээд ерөнхий ярьдаг болохоос биш газар дээрээ очихоор саяын Хууль зүйн сайдын хэлж байна, хуулийн бодлого гэхэд үүнийг хариуцсан чиг үүргийн байгууллагууд эрхэлсэн сайд нар гээд байдаг юм чинь ийм том томъёололтой учраас үүнийг чинь дараа нь дүн шинжилгээ хий гэж байна их том болно шүү дээ. Тэгээр ямар дүн шинжилгээ оруулж ирэх юм, тийм учраас тогтоолын төслийнхөө нэгийг хялбарчилмаар юм байна. Ер нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу байгаа гэдэг дээр санал нэгдэж байна. Энэ хүрээнд жишээлбэл, аль байгууллага оногдсон чиг үүргээ ямар хүн хүч зохион байгуулалт санхүүгийн нөөцөө яаж зохицуулж ажиллаж чадаж байна гэдгийг дүн шинжилгээ хийхээр байх юм бол өнөөдөртөө хамгийн их актуальный байж магадгүй ер нь бол би хувьдаа тийм бодолтой байна.

**А.Бакей:** - Баярлалаа. Л.Цог гишүүн.

**Л.Цог:** - Даргаа энэ чинь үндсэндээ асуулт санал хоёр хамт явах юм шиг байна. Би Х.Тэмүүжин гишүүнтэй санал нэг л байна л даа. Нэгдүгээрт, Төрийн байгуулалтын байнгын хорооны чиг үүргээс халиад явчихсан байна, Засгийн газар, Их Хурлыг бүхэлд нь хийх тийм том асуудал байна шүү дээ. Хоёрдугаарт ингээд заасан томъёолсон асуудал болгон өөрөө том асуудал. Хэтийн хөгжлийн төсөөлөл бүр том асуудал бараг Үндсэн хуулийн түвшинд авч ярьж магадгүй тийм юм байна. Засгийн газрын асуудал бүхэлдээ байж байна. Төсөв, эдийн засаг бүхэлдээ гээд тэгээд хууль тогтоох байгууллага гээд дандаа томоор хамаад хийчихсэн байна л даа. Ингэж хийхгүй, энэ болохгүй. Ерөөсөө бид өөрийнхөө чиг үүргийн дагуу хэрвээ үзье гэвэл төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг үзье гэж хэлж болно. Тэгэхдээ но-той наадах чинь, энэ том өргөн асуудал шүү дээ. Ингээд хамаагүй тавьчихаж болохгүй. Дахин томъёолъё цаг алдаад яах вэ. Яг сугалж аваад яг юу нь хэрэгтэйг бид ойлгоогүй явж байна шүү дээ. Бүгдээрээ хэрэгтэй гэвэл бүгд хэрэгтэй. Их Хурлын бүхэл бүтэн асуудлыг Засгийн газрын асуудалтай багцлаад нэг Хороо ингэх ёс байхгүй. Энэ чинь ямар жишиг тогтох юм мэдэхгүй, харин нөхөрсөг ёсоор татаж аваад ахиад ярьчихвал болох юм биш үү?

**А.Бакей:** - Одоо татаж хэрэггүй.

**Л.Цог:** - Татаж хэрэггүй гэвэл ахиж өөрчилъе яршиг зүгээр. Төрийн байгуулалт өөрийнхөө хэмжээнд юу үзэх вэ гэдгийг томъёолчихъё, би бол саяын өөрийн чинь хэлсэн санаанд явах шиг байна. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу гэдгийг хэлээд байх даа. Юуны уялдааг үзэх гээд байгаа юм бэ? Ямар чиглэлээр гэдгийг үзэхгүй болохгүй шүү дээ. Далай шиг сэлж ерөөсөө болохгүй эргээд бидний гаргах дүгнэлт хачин юм болно, гарах шийдвэр өргөн хүрээтэй хачин юм болно, барьцгүй юм болно шүү дээ. Юу үзэх гээд, юу хэлэх гээд байгаа юм бэ? Хөрсөн дээр буух газар томъёолохгүй бол бид хаана ч унахаа мэдэхгүй байна гэдэгтээ адилхан болох гээд байна шүү дээ. Хоёрдугаарт ингэж хольж хийх юм бол энэ ажлын хэсгийг салгахгүй бол ерөөсөө болохгүй. Их Хурлын гишүүдтэй ороод энэ чинь нэг л ажлын хэсэг болоод дундаа явж байна шүү дээ. Горимын чухал санал гэж бодож байна, цаашдаа бид бодох ёстой. Иймд санал, асуултаа хамт хэлчихье.

**А.Бакей:** - Ингээд асуулт үндсэндээ дууслаа, санал бараг нэг явчихлаа. Саналтай гишүүд саналаа хэлчихье. Тэгээд нэгмөсөн санал хураалгая.

**Д.Батцогт:** - Яах вэ энэ чинь бол айхтар том шийдвэр гаргах гээд байгаа юм байхгүй. Хамгийн гол нь судалж дүгнэлт өгөх ажил хийе гэсэн санаа шүү дээ. Ажил хийх гэж байгаа юмыг бид нар томъёолол дээрээ эргээд харчихъя. Тэгээд ямар ч байсан ажлын хэсгээ байгуулаад юмаа явуулсан дээр байх гэж ингэж бодож байна.

**А.Бакей:** - Баярлалаа. Х.Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** - Би бол жишээ нь юу гэж бодож байгаа вэ гэхээр төрийн байгууллагуудын уялдаа хэрхэн ажиллаж байгаа юм бэ гэдгийг харах гэж байгаа бол их тодорхой баймаар байгаа юм. Ямар төрийн байгууллагууд чиг үүргийн давхцалтай институцууд байгаа юм уу, үгүй юм уу? Эсвэл хуулиар тодорхой чиг үүрэг байх ёстой боловч эзэнгүйдчихээд хэрэгжиж чаддаггүй юмнууд байгаа юм уу, үгүй юм уу? Эсвэл хэд хэдэн бүтэц хамтраад нэг зорилт руу явж байж үр дүн гарах байтал тэр харилцан уялдаа нь байхгүйгээс болоод тэр хүсээд байгаа үр гарахгүй байгаад байгаа юм уу. Яг төрийн байгууллага институцынхаа хувьд эсвэл боловсон хүчнийх нь чадавх, орон тоо эсвэл эдийн засгийнх нь нөөц хүрэлцэхгүйгээс болоод ажлаа хийж чадахгүй байгаа юм уу, эсвэл огт хамаагүй шаардлагагүй чиг үүрэг дээр боловсон хүчин, санхүү гээд бусад нөөцүүдээ үр ашиггүй хаячихаад тийм байдал байгаа юм уу, ийм байдлаар харах юм бол энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны яах аргагүй хийх ёстой ажил мөн. Ийм чиглэлээр судалгаа хийгээд дүн шинжилгээ гаргаад нөөцөө зөв хуваарилъя, чиг үүргээ оновчтой болгоё, эзэнгүй байгаа зүйлүүдийг эзэнжүүлъя, давхар хийдэл янз бүрийн юмнууд байгаа бол зохион байгуулалт бүтцийн хувьд шүү, хуулийн хувьд биш. Ийм асуудлуудаа шийдье гэх юм бол энэ ажлын хэсэг маш үр ашигтайгаа манай төрийн нөөцийг зөв чиг үүрэгтэйгээр зөв зохион байгуулалттайгаар ажиллахад зориулагдсан ажлын хэсэг болж чадна.

**А.Бакей:** - Л.Цог гишүүн.

**Л.Цог:** - Саналаа хэлэх нь зүйтэй юм байна. Энэ чинь бид нар санал гаргаж

дэмжиж байж байгуулна шүү дээ. Тэгэхээр томьёолол нь тодорхой явахгүй бол болохгүй байгаа юм. Үгүйсгэж байгаа юм биш, хэрэггүй гэж байгаадаа биш, ухаан нь манай төрийн байгууллагууд бүтцийн хувьд болохгүй байгаад, эрх мэдэл нь болохгүй байгаад ингээд болохгүй байна уу? Энэ чинь бүтцээсээ болно, эрх мэдлээсээ болно, хүний нөөцөөсөө болно. Гурван том чиглэлийн том багц юм байх ёстой байхгүй юу. Үүнийг алийг нь бид нар үзэх юм бэ? Бүгдийг нь үзэх юм уу, салгаж үзэх юм уу гэдгээ томьёолохгүй бол бидэнд юм хэлж чадахгүй шүү дээ. Юм байгуулахын дон тусчихсан биш бодлоготой явахгүй бол болохгүй шүү дээ.

**А.Бакей:** - Өөр саналтай гишүүд байна уу? Г.Батхүү гишүүн.

**Г.Батхүү:** - Ерөнхийдөө асуудал байгаа л даа. Зүгээр асуудлын хамрах цар хүрээний хувьд гишүүд яриад байх шиг байна. Тэгэхээр би тогтоолыг Төрийн байгуулалтын байнгын хорооны зүгээс хийх ёстой тэр ажил үүргийнх нь хүрээнд гаргах нь зүйтэй гэж бодож байна. Хамгийн ойрхон жишээ харахад Сангийн яам, Эдийн засгийн яам гээд хоёр яам байна. Тэдний ажлын уялдаа холбоо, төсөв боловсруулах, батлах, түүний хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгааг бид анзаарах ёстой шүү дээ. Яагаад гэвэл төсвийн тодотголын асуудлыг ярьж байгаа гэдэг бол хийх гэж хуульчилж өгсөн хуулийг хэрэгжүүлж чадаагүй учраас түүнийгээ гүйцэтгэлийг нь гаргахаас өмнө засаж залруулах гэж байгаа шүү дээ, ийм нарийн юм байгаа юм. Энэ ажил үүргүүдийн уялдааг харах цаг болсон байх. Өнөөдөр төрийн бүтцэд гүйцэтгэх засаглалын ажил хийдэг бодлого хэрэгжүүлдэг байгууллагууд байхгүй болсон. Хуучин бодлогын яам агентлаг байсан, одоо бүгдээрээ яам нэртэй болчихсон, сайд толгойлдог. Бодлого хийдэг юм уу гэхээр оруулж ирж байгаа хууль тогтоомж бодлого нь байхгүй, аж ахуйн яам юм уу гэхээр зэрэг гүйцэтгэл дээр нь тавьж байгаа хяналт үйл ажиллагаа байхгүй. Тухайлбал Авто замын агентлаг гэж байсан татан буугдсан одоо энэ их мөнгөөр хийгдэж байгаа авто замын ажлууд дээр яг гүйцэтгэлд нь хяналт тавиад ажиллаж байгаа тэр бүтэц нь байхгүй болчихсон шүү дээ. Яамны 5, 6 мэргэжилтэн монголын өргөн уудам нутагт барьж байгаа бүх зам дээр очиж хяналт тавина гэж байхгүй шүү дээ. Технологийн хяналт байхгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгээд тендерийн яамд болчихсон, бүгдээрээ барилгын яам болчихсон, яам болгон барилга барьдаг, тендер зарладаг. Тэр тендерийг бүтэн жил хөөцөлдөөд л тэгээд ажил нь дуусаж байгаа ийм л бүтэц рүү бид нар орчихоод байна шүү дээ. Хэн нь энэ аж ахуйн ажлаа хийж, хэн нь тэр бодлогоо хэрэгжүүлэх юм бэ гэдэг асуудлыг хүртэл бид нар ярих ёстой байх гэж бодож байна. Магадгүй өнөөдөр бид нар Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчилж давхихаас илүүтэй ер нь Монгол Улсын Засгийн газар нэг Ерөнхий сайд нэг нам ялахаараа хүнд зориулж, фракцуудад зориулж яам байгуулдаг, агентлаг байгуулдаг ийм бүтэц рүү явах юм уу, үгүй юу. Ер нь ямар бүтэц бүрэлдэхүүнтэй байх ёстой юм бэ гэдгээр хүртэл бид нар жишиг тогтоож өгөх байх гэж бодож байна.

Би Төрийн байгуулалтын байнгын хорооны хийх ажил энэ асуудлын хүрээнд төвлөрөх болов уу гэж харж байна. Түүнээс бид нар хянаад, шалгаад том хөтөлбөр, хэтийн төлөвийг энд хараад байхдаа гол нь биш. Ер нь монголын төр яаж ажиллах ёстой юм бэ, ямар бүтэцтэй байх ёстой юм бэ, ямар хэм хэмжээнд ажиллах ёстой юм бэ, ямар бүтэц бүрэлдэхүүн, хэн нь юугаа хариуцдаг байх ёстой юм гэдгийг

тодруулах цаг болсон байх гэж бодож байна. Тийм учраас би тогтоолын төслийг цэгцлэх юм байна, саналууд байна, батлах нь зүйтэй байх гэж бодож байгаа. Харин энэ ажлын хэсэг нэлээн бүрэлдэхүүн сайтай олон гишүүд оролцсон ийм ажлын хэсэг байна. Ажлын хэсгийг байгуулахдаа цаашдаа бид нар нэг зүйлийг баримталдаг байх ёстой. Хугацаа зааж өгдөг баймаар байгаа юм. Тодорхой хугацаанд нь. Ардаа заалт нь байгаа юм уу, би арын заалтыг нь хараагүй юм байна. Тэгээд дэмжиж байна.

**А.Бакей:** - Н.Батцэрэг гишүүн.

**Л.Цог:** - Би даргаа нэг юм хэлэх үү, би хаячихсан саналаа хэлэх үү? Шаардлага байгааг бүгд ойлгож байгаа учраас ганцхан төрийн байгууллага гэлгүй Их Хурлын даргын дэргэд байгуулаад холбогдох хороодоос орвол яадаг юм бэ? гэсэн ийм санал байж болохоор байна. Гэхдээ энэ Засгийн газар түүний байгууллагын хоорондох уялдаа гэсэн чиглэлийг явцуухан авбал саяын бүх юм гарчих болов уу гэж бодож байна. Тийм гарц бидэнд байна уу даа, миний хувийн санал.

**А.Бакей:** - Н.Батцэрэг гишүүн.

**Н.Батцэрэг:** - Тогтоолын төслийг батлах нь зүйтэй л дээ. Томьёоллыг нь жаахан янзалчих. Хөгжлийн хэтийн төсөөлөл, бодлого, төлөвлөлт гэдэг бол ер нь зүгээр яригдвал яригдах л сэдэв. Гэхдээ өнөөдөртөө тийм актуальный зүйл биш. Магадгүй энэ бол хэрвээ санаачлагч байх юм бол аль нэг парламент бүлэг гэдэг ч юм уу тэгвэл бас ойлгогдоно. Төрийн байгуулалтын байнгын хороо бол би хувьдаа бодохдоо өнөөдрийн тогтолцоон дээр яамд чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа юм бэ, чиг үүрэг ажил үүргийн давхардал байна уу, үгүй юу. Түрүүн бас ярианд гарч байсан шиг хаягдсан чиг үүрэг байна уу, үгүй юу гэдгийг бол үнэхээр үзэх шаардлагатай байгаа. Саяын гишүүд яриад байгаа яамд дээр бодлогын тэр томьёолол алдагдсанаас болоод яг үнэндээ аж ахуй, техникийн чиглэлийн ажил уруу яамд яваад орчихсон, эрхэлсэн сайд нь бодлого гаргана гэж хүлээгээд байдаг яг газар дээрээ бол өнөөдөр тийм юм багатай байгаа гэдгийг нийгэм ч тиймэрхүү шүүмжлэлтэй харж байна, Их Хурлын гишүүд бас хэлж байна шүү дээ. Энэ үүднээсээ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын бодлогыг гэдгээс доош, гэхдээ томьёоллыг нь дахиад жаахан янзалмаар байна. Зөвхөн хэрхэн уялдуулан ажиллаж байгааг үзээд зогсохгүй уялдуулах бол нэг асуудал байна. Өөртөө хуулиар оногдсон чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаа тухай. Энэ дээр бас дүгнэлт гаргах хэрэгтэй. Ийм маягаар томьёолоод магадгүй энэ ажил нь өөрөө бас их объёмтой ажил харагдаж байна шүү дээ. Тэгэх юм бол техникийн хувьд дэд ажлын хэсгүүдтэй байхаар зохион байгуулаад тэгээд тогтоолын төслөө баталъя гэсэн саналтай байна.

**А.Бакей:** - Тэгэхээр гишүүд саналаа хэллээ. Гол санаа нь бол ийм санал хэлж байна шүү дээ. Төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг түүний хэрэгжилтийн талаарх ажлын уялдаа холбоог судлах гэж ийм маягаар нэгдүгээр зүйлийг ийм маягаар гишүүдийн саналд тулгуурлаад өөрчилье. Ер нь энэ

дашрамд хэлэхэд Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх чиг үүрэг бол 11 чиг үүрэг байдаг шүү дээ. Тэр дотор Ерөнхийлөгчийн асуудал байна, Улсын Их Хурлын ч асуудал байна, Засгийн газрын асуудал байна. Бас ч гэж судлах асуудал байгаа. Өнөөдөр ажлын уялдаа байхгүй гэдэг нь бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Энэ дээр зөвхөн ажлын хэсэг байгуулах гээд байна шүү дээ. Түүнээс биш шууд тогтоол, шийдвэр гаргах гэж байгаа юм биш. Тэгээд ажлын хэсэг ажиллаад саналаа боловсруулаад судлаад саналаа танилцуулах үедээ шийдвэрээ тэр үедээ гаргана шүү дээ. Тийм учраас зарчмын гишүүдийн хэлсэн саналд тулгуурлаад нэгдүгээр заалтыг чиг үүрэгтэй илүү уялдуулж бүтэц зохион байгуулалтаа илүү уялдуулаад ажлын уялдааг хангах чиглэлээр томьёолоод, тэгээд ажлын дэд хэсгийг тусад нь зааглаад энэ зарчмын хувьд баталъя гэсэн саналтай гишүүд гараа өргөнө үү? Санал хурааж байгаа шүү. Тоолох хүн байна уу?

11-ээс 6.

Батлагдлаа. Бүлгийн дарга өөрөө хайхрамжгүй хандаад сууж байна шүү. Ингээд гишүүдэд баярласнаа илэрхийлье. Өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө.

**Соронзон хальснаас буулгасан:**

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

М.НОМИНДУЛАМ